

# НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ” АЯНЫ УДИРДАМЖ

## 1. Аяны үндэслэл

Монгол Улсын Засгийн газар Жендэрийн үндэсний хорооноос Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан жил бүрийн 3 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл үндэсний хэмжээнд уламжлал болгон зохион байгуулдаг

Иймд байгууллагын хэмжээнд харилцан хүндлэл, итгэлцэл, эерэг харилцааг төлөвшүүлэх, албан хаагчдын ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Харилцан хүндэтгэе” аянд нэгдэж байна.

## 2. Аяны зорилго

- Хүндэтгэлтэй, соёлтой харилцааг төлөвшүүлэх
- Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх
- Эерэг, хамтын ажиллагаанд суурилсан ажлын орчныг бүрдүүлэх

## 3. Зорилтууд

- Байгууллагын дотоод харилцааны соёлыг сайжруулах
- Албан хаагчдын ёс зүйн мэдлэг, ухамсрыг нэмэгдүүлэх
- Талархал, урамшууллын соёлыг төлөвшүүлэх
- Зөрчил, үл ойлголцлыг соёлтой, шийдэлд суурилсан арга замаар зохицуулах

## 4. Хамрах хүрээ

- Байгууллагын нийт албан хаагчид
- Удирдах болон гүйцэтгэх түвшний ажилтнууд

## 5. Аяны хугацаа

2026 оны 03 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл

## 6. Хэрэгжүүлэх арга хэмжээ

- “Эерэг үг – Эерэг өдөр” постер, мэдээллийг түгээх
- Талархлын самбар ажиллуулах
- “Эерэг хандлага-Эерэг орчин” угтах өдөрлөг зохион байгуулах

## 7. Хүлээгдэж буй үр дүн

- Ажлын байрны эерэг уур амьсгал сайжирна
- Харилцааны үл ойлголцол, зөрчил маргаан буурна
- Байгууллагын дотоод соёл бэхжинэ
- Албан хаагчдын хамтын ажиллагаа, бүтээмж нэмэгдэнэ

## 8. Уриа

“Хүндэтгэл бол бидний хамтын амжилтын үндэс.”

**ЗАХИРГААНЫ ХЭЛТЭС**